

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГТ
ТУССАН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ТӨСӨЛ, АРГА
ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Дундговь аймаг


НЭГ.НОГООН БАЙГУУЛАМЖ (МОД ТАРИХ)

Тус аймгийн нутаг дэвсгэрт сүүлийн жилүүдэд нэн хүчтэй шороон шуурганы улмаас хүн малын эрүүл мэнд, амьдрах орчинд сөргөөр нөлөөлж байгалийн онц аюултай үзэгдлийн давтамж нэмэгдэж байгаатай холбогдуулан цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, элсний нүүдлийг сааруулахад ойн зурвас байгуулах, айл өрх бүр мод, бут тарих ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна.

“ДУНДГОВИО НОГООРУУЛЪЯ” ДЭД ХӨТӨЛБӨР БАТЛАВ.

Тус хөтөлбөрийн хүрээнд аймгийн ИТХурлын тогтоолоор 2022 онд 240.0 сая төгрөг батлуулсан.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн “Ойн менежментийн мастер төлөвлөгөө-2030”-ыг боловсруулан Аймгийн ИТХурлын 2022 оны 12 сарын 05-ны өдрийн 60 дугаар тогтоолоор батлуулсан.



МОД ҮРЖҮҮЛГИЙН ГАЗАР ШИНЭЭР БАЙГУУЛАВ.

Аймгийн хэмжээнд ойн зурвас байгуулахаар 750.91 га, мод үржүүлгийн газар байгуулах зориулалтаар 104.33 га, аймгийн хэмжээнд нийт 855.24 га газрыг 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батлуулсан.




Хулд суманд “Хөх тэрэм” ХХК 3 га талбайд мод үржүүлгийн газар байгуулж хамгаалалтын зурваст 2800 хайлаас, 300 улиас тарьж, үржүүлгийн зориулалтаар 16,000 улиас мөчрөөр, шар хуайс 200,000, гүйлс 100,000, хайлаас 200,000 үрээр тарин 2024 он гэхэд 500,000 ширхэг тарьц, суулгацыг ногоон байгууламжид гаргахаар төлөвлөн ажиллаж байна.



Мөн хүлэмжинд гүйлс, бүйлс, хайлаас, монос, голт бор зэрэг 10000 ширхгийг үрээр, бойжуулах талбайд 150 суулгац, баазын тохижилтод 50 мод, сөөг тарьж ургуулав.



2 суманд мод үржүүлгийн газар шинээр байгуулж 2024 онд 550000 тарьц, суулгац гаргах боломжийг бүрдүүллээ.



БАЙГАЛЬ ХАМГААЛАХ НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛААР 5 ГА ТАЛБАЙД ОЙН ЗУРВАС БАЙГУУЛЛАА.

Сум дундын ойн ангиас Өлзийт суманд 2, Дэлгэрхангай суманд 2, Говь-Угтаал суманд 1, нийт 5 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг тус сумдын Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгүүлж, аймгийн Засаг даргын А/382 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг газар дээр нь актаар хүлээн авлаа. Хот суурин газрын ногоон байгууламжийн эзлэх хувь 1.2 хувиар нэмэгдэж 7.4 хувьд хүрэв.





“ТАРЬЦ, СУУЛГАЦНЫ ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА” ЗОХИОН БАЙГУУЛАВ.

"Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр", "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн", "Дундговь ноогооруульа хөтөлбөр"-ийн хүрээнд "Ногоон хөгжлийн зөвлөгөөн"-ийг зохион байгуулж зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн 05, 10 дугаар саруудад тарьц, суулгац, ойн аж ахуй болон хөдөө аж ахуй газар тариалангийн багаж тоног төхөөрөмжийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 24 иргэн, 1 аж ахуйн нэгжид 87 нэр төрлийн багаж тоног, төхөөрөмжийг нийлүүлж ажиллалаа.







“МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨР”-ИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

“Мод тарих үндэсний өдөр”-ийг 5, 10 дугаар саруудад зохион байгуулж аймгийн хэмжээнд 1053 өрх, 147 аж ахуйн нэгж, байгууллагын 5690 иргэн нийт 122884 мод, сөөгийг тарьж ургуулан ногоон байгууламжийн хэмжээ өмнөх оноос 51 хувиар нэмэгдсэн. Улсын төсвөөр 90.0, орон нутгийн төсвөөр 122.0, хувийн хэвшлийн хөрөнгөөр 116.3 сая төгрөг зарцуулав.





МОДНЫ ТОО СУУЛИЙН 5 ЖИЛИЙН БАЙДЛААР



НОГООН БАЙГУУЛАМЖИД НИЙЛҮҮЛЭХ ТАРЬЦ, СУУЛГАЦ, НӨӨЦ БЭЛТГЭЛ

Сум дундын ойн ангийн Мод үржүүлгийн газраас орон нутгийн хөрсөнд дасан зохицсон 16400, “Байгалиа дээдэлье” ХХК-ны үржүүлсэн 47000, нийт чанарын шаардлага хангасан 63400 ширхэг тарьц суулгацыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нийлүүлээ.



Хайлаас 30, бүйлс 6, заг 5, шар хуайс 4, жигд 3, агч 2, голт бор 0,5 кг үр, улаан сухай 7000, улиас 8700, бургасны 3600 мөчрийг тус тус бэлтгэв. Үүнээс 30 кг үр, 19300 мөчрийг шууд тарьж, 25.5 кг үрийг 2023 оны тарилтад бэлтгэн стандартын дагуу хадгалж байна. Нийт навчит модны үр 55.5 кг, мөчир 19300 ширхгийг үржүүлгийн зориулалтаар бэлтгэн тарьц суулгацын нөөц бүрдүүлэв.



СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААГ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

“Тэрбум” мод үндэсний хөдөлгөөн, “Дундговьо ногооруулъя” дэд хөтөлбөрийн хүрээнд “Ногоон хөгжлийн зөвлөгөөн”, сургалтыг зохион байгуулсан.



"Ногоон хөгжлийн зөвлөгөөн" "Дундговьо ногооруулъя" танхимын сургалт, өвлийн нарлаг хүлэмжид нарийн ногоо тарих, сум дундын ойн ангийн мод үржүүлгийн газрын талбайд үрээр болон мөчрөөр тарих үзүүлэх сургалтад нийт 193, Өмнөговь аймгийн Агропаркийн хүлэмжний аж ахуй, алимны төгөлд туршлага судлах чиглэлээр 36, нийт 229 иргэнийг хамрууллаа.

Мөн Говь-Угтаал сумын “Малчдын зөвлөгөөн”, Өлзийт сумын Буянт багийн өдөрлөг, Сайнцагаан сумын ахмадын холбоо, Онцгой байдлын газар, Говийн-Ирээдүй цогцолбор сургууль 22 аж ахуйн нэгжийн 424 албан хаагчид, малчдад сургалт хийж иргэдийн экологийн боловсролыг нэмэгдүүлж мод тарих ажлыг сурталчлан түгээлээ.



“Дундговьо ногооруулъя” хөтөлбөрийн хүрээнд мод үржүүлэг, ногоон байгууламж, агропарк байгуулах, хүлэмжийн аж ахуй эрхлэх, мандлын цэцэг тарих 3 удаагийн сургалт 15 нийт 61 сургагч багш бэлтгэгдсэнээр иргэн, аж ахуйн нэгж байгууллагад мод тарьж ургуулах аргыг заах түгээн дэлгэрүүлэх нөхцөл, боломж бүрдлээ.

“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”, “Зөв мод-Зөв арчилгаа” аяны хүрээнд 15 сумын ерөнхий боловсролын сургуулийн 12 эко клубуудын 122 сурагчид оролцсон “Бүтээе-хамгаалъя” чуулганыг зохион байгууллаа.



Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад байгаль орчноо хайрлан хамгаалахын ач холбогдол монгол зан заншлыг дээдлэх "Тэрбум мод үндэсний хөдөлгөөний төлөвлөлт", "Мод тарьж ургуулах технологи"-ийн сургалтыг зохион байгууллаа.



ХОЁР.ЦАХИМ ШИЛЖИЛТ

“И-МОНГОЛИА” ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛЛАА.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт “И-Монголиа” төрийн үйлчилгээний төвийг шинээр байгуулан иргэдэд цахим төрийн үйлчилгээ үзүүлэх, олон нийт, аж ахуйн нэгжид мэдээлэл сурталчилгаа хийх, иргэдэд заавар зөвлөмж өгч цахим төрийн үйлчилгээг нэмэгдүүлэн ажиллах чиг үүрэг бүхий ажлын байр шинээр бий болгон ажиллуулсны үр дүнд аймгийн хэмжээнд төрийн цахим үйлчилгээний “E-Mongolia” хэрэглэгчдийн тоо: 2021 онд 11486 байсан бол 2022 онд 16223 болж өмнөх оноос 4737 иргэнээр өссөн үзүүлэлттэй байна.




2022 оныг “хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж, төрийн албан хаагч болон иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх чиглэсэн сургалт, арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.









Мэдээллийн “Dundgovi”, Санал хүсэлтийн “Дундговь” 2 аппликейшныг хэрэглээнд нэвтрүүлж иргэд санал хүсэлтээ цахимаар ирүүлэх боломжийг бүрдүүлсэн.



2022 онд аймгийн цахим хуудасны мэдээ, мэдээлэл нийт 1112 мэдээ нийтлэгдсэнээс цагийн үеийн 357, төрийн байгууллагуудын 345, сумдын 191, зарлалын шинжтэй-80, фото-26, видео мэдээ-95 нийтлэгдсэн. 2022 онд сайтын хандалт 30960 байна.



Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан нийт 102 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг АЗДТГ-ын нээлттэй утас, аймгийн албан ёсны цахим хуудас болон ЗГ-ын олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан хүлээн авч шийдвэрлэлт 98,2 хувьтай байна. Нээлттэй утас, цахим сайтаар өргөдөл гомдол хүлээн авснаар иргэд биечлэн ирэх шаардлагагүйгээр орон зайнаас үл хамааран санал хүсэлтээ илэрхийлэх боломж бүрдсэн.



ГУРАВ.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ



Нийтийн эдэлбэр талбайн бүх нийтийн их цэвэрлэгээг 15 суманд 23 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 87 аж ахуйн нэгж, байгууллагын 3282 ажилчид, албан хаагчид, иргэдийг хамруулан нийт 261.3 га талбайгаас 422.5 тн энгийн хог хаягдлыг орон нутгийн төсвийн 0.8 сая төгрөгийн хөрөнгө зарцуулан цэвэрлэж хог хаягдлын нэгдсэн цэгт төвлөрүүлсэн.




 Хулд сумын Засаг даргын 2022 Оны 03 сарын 25-ны өдрийн А/21 дугаар захирамжийн дагуу
2022.04.08-нд
 ХУЛД СУМЫН БҮХ НИЙТИЙН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭТЭЙ
 Иргэд, Аж ахуйн нэгж, айл өрх ойр орчмын талбайн хог хаягдлыг цэвэрлэнэ үү.
ХОГГҮЙ ХУЛДЫН ТӨЛӨӨ ХАМТДАА




“Ангилъя-Ариглая-Ашиглая” бүсчилсэн аянг 14 сумын хэмжээнд удирдамж гарган 2022 оны 04 дүгээр сараас 09 дүгээр сарыг дуустал хугацаанд зохион байгуулсан.



84 ААНэгж, байгууллагын 312 хүнд байгаль орчинд ээлтэй хэрэглээний соёл хэвшүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах дадал зуршлыг төлөвшүүлэх, хүний эрүүл мэнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар сургалт зохион байгуулсан.





12 суманд хуванцар цуглуулах болон 3 төрлөөр ангилан ялгах, эмнэлгийн хог хаягдал ялгах зориулалт бүхий хогийн сав нийт 94 аж ахуйн нэгж, байгууллага шинээр байршуулж, аймгийн хэмжээний нийт ангилан ялгах хогийн сав 224 болж нэмэгдэв.



Нийт 5 суманд 3 төрлийн 17.7 тн дахивар хог хаягдлыг дахивар нөөц авах цэгтээ ангилж цуглуулж тушаасан.

2 суманд уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулагч 3 ААНэгж нийт 45 тн аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад нийлүүлсэн.



Ингэснээр 2022 онд аймгийн хэмжээнд нийт 62.7 тн буюу өмнө оны үзүүлэлтээс 5.4 дахин их хог хаягдлыг үйлдвэрт нийлүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулсан үзүүлэлттэй байна.



Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг гаргахдаа Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу суурь түшинг хүрсэн түвшинтэй харьцуулан статистик мэдээлэлтэй тулган журмын 6.2.1-т заасан арга зүйгээр үнэлэв.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ДААРИЙМАА